

**“Аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 2023 оны хэрэгжилт**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин, үр дүн	Үнэлгээ
<b>1. НЭГ. ҮНДЭСНИЙ НЭГДМЭЛ ҮНЭТ ЗҮЙЛ</b>								
1	1.1. Үндэсний бахархал, эв нэгдэл	1.1.1. Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох, хүүхэд залууст Цэрэг-эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэн Монголчуудын уламжлалт төрт ёсоо дээдлэх үзлийг дэлгэрүүлнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээ	Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох талаар 1 арга хэмжээг зохион байгуулсан.	Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох, хүүхэд залууст Цэрэг-эх оронч үзэл хүмүүжил олгох зорилгоор үйл ажиллагаа зохион байгуулсан байна	Үндэсний бахархал, Монгол өв соёлыг өвлүүлэх, үндэсний дархлаа бий болгох, эх оронч үзэл хүмүүжил төлөвшүүлэх зорилгоор “Хан Хэнтий - 100” хүүхдийн урлагийн их наадам, гэр бүл, хүүхэд залуучууд руу чиглэсэн 10 удаагийн хэмжээг зохион байгуулж нийт 5028 хүүхэд, насанд хүрэгчдийг хамруулсан.	100%
2	1.2. Нүүдлийн соёл иргэншилт Монгол	1.2.1. Өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвар, дадалтай иргэнийг төлөвшүүлж, монгол өв соёлыг түгээн дэлгэрүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээ хамрагдсан хүний тоо	Өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадварыг дээшдүүлэх 2 арга хэмжээг зохион байгуулж 175 иргэнийг хамруулсан.	Өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг, үндэсний соёлын мэдлэг, чадвараа сургах сурталчлах ажил зохион байгуулж хамрагдагчдын тоог нэмэгдүүлэх	Улс болон аймгийн уралдаан тэмцээн, шавь сургалтыг шат дараатай зохион байгуулж 200 гаруй морин хуурч 130-аад уртын дуучид, 20 хүүхдэд бийрэн бичлэгийн төрлөөр сургаж, бэлтгэгдсэн. Аймгийн хэмжээнд Соёлын боловсрол олгох чиглэлээр 8 сургалт, арга хэмжээ зохион байгуулснаас гадна уншигчдын тоог нэмэгдүүлж соёлын боловсролын суурь түвшинг ахиулах зорилгоор зөөврөөр болон танхимаар 13730 хүнд 17691 номоор үйлчилгээ үзүүлж 7450 уншигчаар өссөн үзүүлэлттэй гарсан нь өмнөх оныхоос 9.5 % -аар дээшилсэн байна.	100%

3	1.3. Монгол хэл, бичиг	1.3.1. Бүх шатны сургалтын байгууллагад Монгол хэл, бичгийн боловсролыг суралцагчдад чанартай эзэмшүүлж, хүн бүрийн эх хэлний боловсролыг дээшлүүлнэ.	-	Бүх шатны боловсролын байгууллагад чиглэсэн үйл ажиллагаа хамрагдсан хүний тоо	Хамрагдсан хүний тоо 1500 хүн хамрагдсан	Эх хэлний боловсролыг чанаржуулах, багш суралцагчдыг чадваржуулах, анги массаар ахицтай сургах болон багаар хамтран чадварыг хөгжүүлэх, дэмжих зорилгоор бүх шатны боловсролын байгууллагад төлөвлөгөөт үйл ажиллагаа зохион байгуулж, хамрагдагчдын тоог нэмэгдүүлэх	С.Гомбожавын нэрэмжит Монгол бичгийн олимпиадад 80 сурагч, 20 багш, "Би Монгол хүн" ерөнхий сэдвийн дор Монгол бичгийн хичээлд цэцэрлэгийн 5600 гаруй хүүхэд, ЕБС-ийн 16900 гаруй суралцагч, "Бидний хичээлийн тэмдэглэл" үйл ажиллагаанд 620 суралцагч тус тус оролцсон. Нийт 886 багш, 23200 суралцагчид хамрагдсан нь өмнөх оноос 12 %-аар нэмэгдсэн.	90%
4		1.3.2. Монгол хэл, бичгийг нийтийн болон албан хэргийн түвшинд зөв хэрэглэж хэвшүүлнэ.	-	Зохион байгуулсан арга хэмжээ хамрагдсан хүний тоо	-	Монгол хэл, бичгийг нийтийн хэрэглээнд нэвтрүүлэхэд чиглэн сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, нийтийн болон албан хэргийн түвшинд хэрэглэх чадварт чиглэсэн арга хэмжээ, сургалт, үйл ажиллагаа зохион байгуулах	Монгол хэл, бичгийг олон нийтэд түгээн дэлгэрүүлэх, сурталчлах зорилгоор Харилцан суралцаж хамтдаа хөгжье аян-2000 хүн, Үндэсний бичгээ манлайлан суралцъя цахим чалленж-116 дарга, Бидний Монгол бичиг үзэсгэлэнд-300, Бичиг үсгийн баяр-1600 хүнд хүрч ажилласан. Монгол бичгийн сургалтад 1-р түвшинд 934, 2-р түвшинд 475, 3-р түвшинд 1736 оношлогдон, сургалтад хамрагдаж байна. Монгол бичгийн цахим сургалтад 18 сумын 2800 гаруй албан хаагч үзэж, сорил гүйцэтгэн, үнэмлэх авсан.	100%

5	1.4. Дэлхийн Монгол	1.4.1. Орон нутгийн түвшинд үндэсний соёл, урлаг, зан заншил, ахуй, спорт, хоол хүнс судлалыг хөгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.	-	Хэрэгжсэн арга хэмжээний тоо	-	Үндэсний соёл,урлаг зан заншил, ахуйн талаар 2-оос доошгүй арга хэмжээ зохион байгуулсан байна.	Хан Хэнтий аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн баяр наадмын хүрээнд "Хан Хэнтийн нүүдэлчид-2023" ардын урлагийн наадамд 18 сум 4 тосгоны соёлын төвүүд, Соёлын Яамнаас зохион байгуулсан "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалд Хэнтий аймгаас нийт 61 хүний бүрэлдэхүүнтэй оролцсон.	100%
<b>2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ</b>								
6	2.1. Боловсрол	2.1.1. 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулж, сургуульд бэлтгэгдсэн байдлыг хангана.	-	Хамран сургалтын хувь	94.3	95	2023-2024 оны хичээлийн жилд 36 цэцэрлэгт 5 настай нийт 1722 хүүхдээс 1674 хүүхэд /97.2 хувь/ нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамрагдсан.	100%
7		2.1.2. Багшийн мэргэжлийн ур чадварыг тасралтгүй дээшлүүлэн, хөдөлмөрийн бүтээмжид суурилсан үнэлэмжийг хэрэгжүүлж, нийгмийн баталгааг хангана.	30	Үнэлсэн байдал, шагнал урамшууллын хэмжээ	26 сая төгрөг	30 сая	Аймгийн Засаг даргын нэрэмжит "Шилдэг багш шалгаруулах" уралдаанд 26 багш шалгарч Үүнээс шилдэг 21 багшийг тус бүр 500,000 мянган төгрөгөөр, шилдэг 5 оролцогчийг 75 сая төгрөгөөр тус тус шагнаж урамшуулсан. Хэрлэн сумын ИТХ-ын 16 дугаар хуралдаанаар батласан "Чадварлаг багш, чанартай боловсрол" хөтөлбөрийн хүрээнд 12 багшийг тус тус 1 сая төгрөгөөр урамшуулсан.	100%
8		2.1.3. Сургууль, цэцэрлэг, дотуур байрын хүчин чадал, ашиглалт, бүтэц, хэв шинж, байршлыг оновчтой тогтооно.	-	Судалгаа хийгдсэн эсэх	-	Сургуулиудад судалгаа хийж шаардлагатай сургуулийн хэв шинжийг өөрчилсөн байна	Бор-өндөр цогцолбор сургуулийн ангилалд дунд, ахлах ангийн сургалтын үйл ажиллагааг явуулахаар өөрчилж, Бор-өндөр бага сургуулийг шинээр байгуулсан, Байгалийн ухаан, технологийн чиглэлээр гүнзгийрүүлсэн сургалттай 5-р сургуулийг шинээр байгуулсан.	100%

9		2.2.1. Халдварт болон халдварт бус өвчнөөс сэргийлэх, хянах, эрт илрүүлэлтийг эрчимжүүлж, нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын хариу арга хэмжээ, бэлэн байдлыг бэхжүүлнэ.	-	Хамрагдалтын хувь, нөөцийн бэлэн байдлын хувь	хүн амын хамрагдалтын хувь 56%, нөөцийн бэлэн байдал 60%	хүн амын хамрагдалтын хувь 70%, нөөцийн бэлэн байдал 85%	Сургалт сурталчилгаанд хамруулсан нь хүн амын 71.3%-ийг (56368 иргэн) эзэлж байна. Эмийн 46, эмнэлгийн хэрэгсэл 42, нэг удаагийн хувийн хамгаалах хэрэгсэл 11, ариутгал халдваргүйтгэлийн бодис 7, түргэвчилсэн оношлуур 5 нэр төрлөөр тус тус нөөц бүрдүүлж, хангалт 86.1%-тай байна.	100%	
10	2.2. мэнд	Эрүүл	2.2.2. Хүн амын эрүүл мэндийн мэдлэг боловсролыг дээшлүүлж, нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг эрчимжүүлэх замаар иргэдийн урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо шинжилгээнд хамрагдалтыг нэмэгдүүлж, сэргийлж болох нас баралтын түвшинг бууруулна.	-	Хүн амын хамрагдалтын хувь	53%	60%	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах сургалт сурталчилгаанд 32600 иргэд буюу зорилтот бүлгийн хүн амын 64.4%, урьдчилан сэргийлэх үзлэгт 21275 хүнийг хамруулсан нь зорилтот бүлгийн 60.2%-д тус тус хүрч ажилласан. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй зүрх судасны өвчлөл болон хоол боловсруулах тогтолцооны өвчлөл өмнөх оны мөн үеийн түвшинд байна.	100%
11			2.2.3. Яаралтай тусламжийн чанар, хүртээмж, чадавхыг сайжруулж, эрүүл мэндийн байгууллагын барилгын асуудлыг шийдвэрлэж, нэн шаардлагатай тоног, төхөөрөмж, авто машины парк шинэчлэлийг хийнэ.	-	Шийдвэрлэсэн барилга, автомашин, багийн эмчийн унааны тоо	7 багийн эмчийг унаагаар хангасан.	3 барилга, 2 автомашин, 2 багийн эмчийн унааг шийдвэрлэх	2023 онд 1 сумын шинэ барилга, 5 СЭМТөвийн өргөтгөл 100% тус тус ашиглалтад оруулсан. УТХО, ОНХО-ын 188.2 сая төгрөгийн санхүүжилтээр 9 эрүүл мэндийн байгууллага, багийн эмчид шинээр автомашин олгосон.	100%

12		2.2.4. Эрүүл мэндийн салбарт цахим үйлчилгээг өргөжүүлэн эрүүл мэндийн мэдээллийн сан бүрдэж, өдөр тутмын оношилгоо, үйлчилгээнд алсын зайн технологийг бүрэн нэвтрүүлнэ.	-	Байгууллагын тоогоор	АНЭ-ийн 1 тасаг онлайнаар оношилгоо, эмчилгээ зөвлөгөө өгч ажиллаж байна.	2 байгууллагаар нэмэгдүүлсэн байна.	Энэ онд ДЭМБ-ээс 22.4 сая төгрөгийн санхүүжилтээр Өмнөдэлгэр, Баян-Адарга, Батширээт, Биндэр сумын Эрүүл мэндийн төв мобайл технологи ор хангагдан ажиллаж байна.	100%
13		2.2.5. Орон нутагт эмийн бодлогыг хэрэгжүүлж, антибиотикийн хяналтыг сайжруулна.	-	Эмийн бодлогын хэрэгжилтийн хувь	80%	88%	Холбогдох байгууллагууд хамтран 45 эмийн сангийн үйл ажиллагаа болон антибиотикийг жороор олгож буйд хяналт хийсэн нь нийт эмийн сангийн 88.3%-ийг эзэлж байна.	100%
14		2.2.6. Эрүүл мэндийн салбарын хүний нөөцийн ур чадвар, нийгмийн хамгааллыг сайжруулна.	-	Нийгмийн хамгааллын хөтөлбөрийн хэрэгжилтийн хувь	70%	80%	2023 оны жилийн эцсийн байдлаар нийгмийн хамгааллын хөтөлбөр 82.4%-тай хэрэгжүүлсэн. Баянмөнх, Дадал, Мөрөн, Баянхутаг сумын Эрүүл мэндийн төвд шинээр ажилд орсон эмч нарыг эмчийн байраар хангаж 20 сум тосгоны Эрүүл мэндийн төвийн эмчийн байраар 19 их эмч, 5 сувилагч, 1 бага эмч хангагдсан.	100%
15	2.3. Гэр бүл	2.3.1. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, төлөвшлийг дэмжихэд эцэг, эх, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, хүүхэд хамгааллыг сайжруулна.	-	Шинээр байгуулагдсан эцэг эхийн зөвлөлийн тоо	76	шинээр 20-аас доошгүй байгууллага эцэг эхийн зөвлөл байгуулсан байна	2023 онд 37 Аж ахуйн нэгж байгууллага эцэг эхийн зөвлөлтэй болж өмнөх оноос 10 хувиар өссөн.	100%
16		2.3.2. Хөгжлийн бэрхшээлтэй хүн, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр	-	Ахмадын сантай болсон байгууллагын тоо, хүртээмжийн үнэлгээ хийсэн	ахмадын сантай 6 байгууллага, үнэлгээ хийсэн 11 байгууллага	10-аас доошгүй байгууллагад ахмадын сан байгуулж ажиллана.30-аас доошгүй байгууллагад	2023 онд 21 сум тосгоны Засаг даргын Тамгын газар, Захирагчийн албаны байр, 3 худалдааны 3 төвд хөгжлийн бэрхшээлтэй хүний орчны хүртээмжийн үнэлгээ хийж, зөвлөмжийг хүргүүлэн ажилласан. Мөн 10 аж ахуйн нэгж байгууллагад	90%

		эрхлэх боломжоор хангана.		байгууллагын тоо		үнэлгээ хийж зөвлөмж хүргүүлсэн байна.	Ахмадын сан байгуулах зөвлөмж, чиглэлийг хүргүүлэн ажилласан.	
17		2.3.3. Хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, сэтгэл зүйн дарамт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгаж эрсдэлээс урьдчилан сэргийлнэ.	-	Хүүхдэд ээлтэй байдлын индекс	хүүхдэд ээлтэй байдлын индекс 4	хүүхдэд ээлтэй байдлын индекс 1 нэгжээр ахисан байна.	2023 оныг "Хүүхдийн хөгжил хамгаалал"-ын жил болгон үргэлжлүүлэн зарлаж, 105 сая төгрөгийг орон нутгийн төсөвт тусган хүүхдэд ээлтэй байдлын индекс 1 нэгжээр ахиулах төлөвлөгөөний хэрэгжилт 90-ээс дээш хувьтай хэрэгжсэн. 2023 оны статистикийн дүн мэдээ нэгтгэгдэж 2024 оны 02 дугаар улиралд 2023 оны индексийг тооцно.	90%
18	2.4. Хүнд ээлтэй амьдрах орчин	2.4.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг тодорхойлох чадвартай болж, хүнсний аюулгүй байдал хангагдана.	-	Аюулгүй байдал хангагдаж буй эсэх	Стандартчилал хэмжил зүйн хэлтэс, МХГ-тай хамтран хүнс үйлдвэрлэгч 60 гаруй иргэний бүтээгдэхүүний сав баглаа боодолд үзлэг хийж хаяг шогын стандарт, тавигдах шаардлагын талаарх мэдээллийг хүргэж ажиллалаа. 100 гаруй иргэдэд хүнсний аюулгүй байдлын 6 удаагийн сургалтыг хийсэн.	Хүнсний аюулгүй байдлыг хангах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Хяналт шалгалтын удирдамж ийн дагуу стандартын хэрэгжилтийн байдалд хяналт тавьж, хэрэгжилтийг хангуулах, илэрсэн дутагдлыг арилгуулах, гарч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч шалгалт хийж ажиллалаа.	100%
19		2.4.2. Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг сайжруулна.	-	Ажлын гүйцэтгэлээр	Барилгыг ашиглалтад хүлээн авахад ногоон байгууламжийг хүлээн авсан.	Ногоон байгууламжийн хэмжээ нэмэгдсэн байна.	2023 онд Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээд нийт 644 айлын орон сууцны барилга баригдахаар төлөвлөгдсөнөөс 30 айлын 3 орон сууц ашиглалтад орсон. Тэдгээрийн нийт 1,16 сая м2 эдэлбэр	90%

							газрын 30 хүртэл хувь буюу 0,35 сая м2 газарт тохижилт ногоон байгууламж байгуулахаар зургийн даалгаварт тусгаж холбогдох газруудад хүргүүлсэн.	
20		2.4.3. Агаар, ус, хөрсний бохирдол болон дуу чимээг багасгаж, цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.	-	хэрэгжилтээр	Агаар, хөрсний бохирдлын төлөв байдлын суурь судалгаа хийгдсэн. Аймгийн нийт ногоон байгууламжийн талбайн хэмжээ 45 га	Ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлсэн байна.	Чингис хотын 49 өрхийг гэрийн дулаалга, агаар сэлгэлт, цахилгаан халаагуурын чип багцад хамрууллаа. 18 сумын хэмжээнд 3000 гаруй га талбай дахь 5640 тн ил задгай хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт зөөж, дарж булшлан, 8 суманд стандартын шаардлага хангаагүй хөрс бохирдуулагч 114 нүхэн жорлонг буулгаж, 15 муу усны нүхийг булж устган, амралт, сувилал, наадмын талбай, голын эрэг дагуу 25 эко жорлон, 10 био жорлон суурилуулж, хөрсний бохирдлыг буурууллаа. Нийтийн эзэмшлийн талбайд хөл газрын ургамлын хэмжээг бууруулах, иргэдийн амьдрах орчны ая таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор 6.1 га талбайд зүлэгжүүлэлтийн ажил хийж, ногоон байгууламжийн хэмжээг 65 мянгаар нэмэгдүүлж 209.6 мянган мод тарьж цэвэр, ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүллээ.	90%
21		2.4.4. Хот суурины үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.	3481,0	Ажлын гүйцэтгэлээр	Хэрлэн, Цэнхэрмандал сумын газар шорооны ажил хийгдсэн.	Хэрлэн сумын үерийн далангийн ажил ашиглалтад оруулна.	Хэрлэн сумын “Үерийн усны хамгаалалтын далан суваг”-ийн ажил 6.2 км ус зайлуулах бетон суваг, аймгийн төвийн авто замын 8,6км ус зайлуулах сувгийн ажлууд бүрэн дууссан.	90%
22	2.5. Хөдөлмөрийн зах зээл	2.5.1. Хөдөлмөр эрхлэлийн түвшинг 5-аас дээш хувиар нэмэгдүүлнэ.	-	Хувиар	62.5	64	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 712 иргэнийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамруулж 1.59 тэрбум төгрөгийг зарцуулж, шинээр 1250 байнгын болон түр ажлын байр бий болсон. 2023 оны хөдөлмөр эрхлэлтийн түвшин 2024 оны I улиралд гарна. 2023 оны хөдөлмөр	90%

							эрхлэлтийн түвшин 2024 оны I улиралд гарна.	
23		2.5.2. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.	-	албан бус хөдөлмөр эрхлэгчдийн тоо	25171	Албан бус хөдөлмөр эрхлэгчдийн бүртгэлийг шинэчлэн ХЗЗ-н бүртгэл мэдээллийн нэгдсэн санд оруулна.	Албан бус хөдөлмөр эрхэлж байгаа 87 иргэнийг мэдээллийн санд нэмж бүртгэсэн.	100%
<b>3. ГУРАВ. АМЬДРАЛЫН ЧАНАР БА ДУНДАЖ ДАВХАРГА</b>								
24	3.1. Нийгмийн хамгаалал	3.1.1. Халамжийн үйлчилгээг хүн амын бүлгүүдийн ялгаатай хэрэгцээ, нийгмийн хөгжлийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн ил, тод нээлттэй, чирэгдэлгүй болно.	-	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэдийн тоо	9040	Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг иргэдийн тоо буурсан байна.	Халамжаас-Хөдөлмөрт арга хэмжээний хүрээнд Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг 595 өрхийн 3071 иргэнээс 25 өрхийн 120 иргэн хяналт шалгалтын үр дүн болон хөдөлмөр эрхлэх болсон үндэслэлээр хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнээс түдгэлзүүлсэн.	100%
25	3.2. Орлогод нийцсэн орон байр	3.2.1. Нийгмийн даатгал төлдөг бага, дунд орлоготой иргэдийг анх удаа орон сууц худалдан авахад нь орон сууцны хөнгөлөлттэй зээлд хамруулж дэмжинэ.	-	Зээлд хамрагдсан иргэдийн тоо	50	70 хүртэл	2023 онд аймгийн хэмжээнд нийт 44 иргэнд зээл олгосон байна. "Иргэдэд орон сууцны ипотекийн зээл олгоход хамтран ажиллах" гэрээний хүрээнд 20 иргэнд шинээр зээл олгохоор шийдвэрлэсэн.	100%



26		3.2.2. Дотооддоо үйлдвэрлэсэн барилгын зарим үндсэн нэр төрлийн хямд материалаар барьсан бага өртөгтэй орон сууцаар хангана.	1900	ОНӨҮГ байгуулсан эсэх	-	хямд үнэтэй орон сууц ашиглалтад оруулна.	Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар барилгын тодорхой хувийг дотоодын бараа материалаар хийж гүйцэтгэн хямд өртөгтэй 100 айлын орон сууцны 3 блок барилга ашиглалтад орж, "Инвест Хэнтий" үйл ажиллагааны үеэр "Эм Си Эс Си" ХХК-тай хамтран "Хэнтий-Стандарт" 250 айлын орон сууцны хороолол барих ажлын санамж бичгийг байгуулж барилгын ажил эхлээд байна.	90%
27		3.3.1. Залуучуудад бизнес эрхлэх зорилгодоо хүрэхэд шаардлагатай дэмжлэг, туслалцааг үзүүлж, орчин, нөхцөлийг бүрдүүлнэ.	-	Төсөл хөтөлбөрийн хүрээнд байнгын ажлын байртай болсон залуучуудын тоо	10	50-аас доошгүй залуучуудыг байнгын ажлын байраар хангана.	73 залуучуудыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрт хамруулж байнгын ажлын байраар ханган ажилласан байна.	100%
28	3.3. Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес	3.3.2. Малчид, тариаланчдыг бизнесийн тогтвортой орлогын эх үүсвэртэй болгоно.	-	Гэрээт малчнаар ажиллаж байгаа иргэний тоо	-	Хүсэлт гаргасан иргэдийг гэрээт малчин хөтөлбөрт бүрэн хамруулсан байна.	12 сум 1 тосгоны хүсэлт гаргасан 23 ажил олгогчтой 23 туслах малчин гэрээ байгуулж 56 байнгын ажлын байр бий болсон.	100%
29		3.3.3. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн, иргэд, аж ахуйн нэгжийн орлогыг нэмэгдүүлнэ.	-	аялал жуулчлалын салбарын орлого нэмэгдсэн эсэх	дотоодын 48,6 мянга гаруй жуулчин аялж 7,2 тэрбум төгрөгний орлого бий болж аймгийн эдийн засагт үр өгөөж оруулсан.	Иргэд, аж ахуйн нэгжийн аялал жуулчлалын салбар дахь үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж, аймгийн эдийн засагт оруулах үр өгөөжийг нэмэгдүүлнэ.	Иргэд, аж ахуйн нэгжийн аялал жуулчлалын салбар дахь үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжиж шинээр аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэд, ААН-ийн тоо 7 хувиар, ажлын байр 17.7 хувиар тус тус нэмэгдэж, 14.0 тэрбум төгрөгийн орлого олж аймгийн эдийн засагт оруулах хувь нэмэр үр өгөөж суурь түвшнээс 50 хувиар нэмэгдээд байна.	100%

30		3.3.4. Хоршоологчдыг дэмжих арга хэмжээг шат дараатай хэрэгжүүлнэ.	-	үйл ажиллагааны гүйцэтгэлээр	18 суманд бүртгэлтэй 136 хоршоонд хоршооны хөгжлийн үнэлгээний ажлыг зохион байгуулж ажилласан. Мөн 3 сумын 5 хоршоонд зохистой дадлын хэвшүүлэх ноолуурын чанарыг сайжруулах талаар санамж бичигт байгуулсан.	Хоршоог дэмжих арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.	Хоршоо хөгжүүлэх сангаас ахуйн үйлчилгээний чиглэлээр 20 иргэн, 2 аж ахуйн нэгжид 445.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл олгосон. Жаргалтхаан, Батноров, Хэрлэн, Бор-Өндөр сумдад хувийн болон ОНХС, улсын төсвийн 651.0 сая төгрөгийн хөрөнгөөр ахуйн үйлчилгээний салбар төвүүд байгуулагдан ашиглалтад орсон.	70%
31	3.4. Эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг	3.4.1. Хүн амд үзүүлэх биеийн тамир, спортын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ.	26	Биеийн тамираар хичээллэгч-дийн тоо	Биеийн тамирын арга хэмжээнд нийт 7200 иргэн хамрагдсан	Биеийн тамир, спортын арга хэмжээнд нийт 8400 иргэдийг хамруулсан байх	2023 онд нийт 19 спортын төрлөөр 60 секц дугуйланд 890 тамирчид хамрагдаж байна. Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 24 спортын төрлөөр 35 удаагийн тэмцээн уралдаанд 4527 тамирчин, Улс, бүсийн спортын наадмын аварга шалгаруулах спортын уралдаан тэмцээнд өсвөр үе, насанд хүрэгчид спортын 14 төрөл, 27 удаагийн тэмцээнд нийт 452 тамирчид оролцсон байна. Мөн УАШТэмцээнээс 198 багц медаль хүртэж 2022 онтой харьцуулахад медалийн тоо 35-аар нэмэгдэж тамирчдын амжилт 21%-иар өссөн байна. Нийт Биеийн тамир, спортын арга хэмжээнд нийт 8511 иргэдийг хамруулсан байна	100%

32		3.4.2. Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт цогцолбор, талбайг нэмэгдүүлнэ.	-	Шинээр ашиглалтад орсон спортын зориулалтын стандарт цогцолбор, талбайн тоогоор	3 суманд спорт заал шинээр баригдсан, Гадаа талбай 3 баригдсан	Спорт цогцолбор байгуулах бэлтгэл ажлыг хангах хандивын аяныг эхлүүлсэн байна.	2023 оны хагас жилд Хэрлэн суманд Хэрлэн лаборатори 1-р сургуулийн спорт заал, Баянмөнх сумын спорт заал, Хэрлэн 4-р сургуулийн спорт заал, сүүлийн хагас жилд Өмнөдэлгэр 8,9 тэрбум төгрөгийн өртөг бүхий спорт заал, Жаргалтхаан суманд 8,1 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа цуг спорт заал тус тус Улсын төсөвт хөрөнгөөр шинээр ашиглалтад орсон. Нийтийн биеийн тамираар хичээллэгсдийн тоо өмнөх оны мөн үеэс 5000 хүнээр нэмэгдсэн байна.	100%
33		3.4.3. Нийтийн биеийн тамирыг эрүүл, идэвхтэй амьдралын хэв маяг, аж төрөх ёсны салшгүй хэсэг болгон хөгжүүлнэ.	50	Биеийн тамираар хичээллэгчдийн тоо	3800 иргэд	Биеийн тамираар хичээллэгчдийн тоог өмнөх оноос нэмэгдүүлнэ	2023 онд БТСГазарт бүртгэлтэй 23 спортын холбоо, 15 клуб, 6 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж биеийн тамирын чиглэлээр "Өглөөний дасгал" хөтөлбөр, "Цаг гаргая", "Цахим алхалт 2023" аяныг тус тус зохион байгуулсан ба биеийн тамирын 85 арга хэмжээнд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 15110 иргэн хамрагдсан нь өмнөх оноос 5%-аар нэмэгдсэн байна.	100%
<b>4. ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСАГ</b>								
34	4.1. Чадварлаг Хэнтийчүүд	4.1.1. Төсвийн хөрөнгийг эдийн засаг, нийгмийн хөгжилд чиглүүлсэн, үр ашигтай, хариуцлагатай төсөв, санхүүгийн бодлого баримтална.	-	Бодлогыг баримтлан төсөв батлуулсан эсэх.	87251	Бодлогыг баримтлан төсвийг боловсруулан батлуулсан байна.	Орон нутгийн 2023 оны нэгдсэн төсвийг 81.6 тэрбум төгрөгөөр батлуулсан. Төсвийн тухай хууль болон холбогдон гарсан тогтоол шийдвэр, журмын хэрэгжилтийг ханган ажилласнаар төсвийн гүйцэтгэл 86.9 хувь буюу 70.9 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч батлагдсан төсөвт байтаан ажиллалаа.	100%
35		4.1.2. Дотоодын нийт бүтээгдэхүүнийг жил бүр тогтвортой өсгөж, ажил	-	Дотоодын нийт бүтээгдэхүүний дүнгээр	Зах зээлийн үнээр 481,007.2 мянган төгрөг	Дотоодын нийт бүтээгдэхүүн өссөн байна.	2023 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн байдлаар 2022 оны нэг хүнд ноогдох ДНБ 9,175.25 мянган төгрөг буюу 2021 оноос 1,580.25 мянган	70%

		эрхлэлтийг нэмэгдүүлнэ.				төгрөгөөр өссөн байна. 2023 оны ДНБ-ний дүн гарах хугацаа болоогүй байна.		
36		4.1.3. Төсөл хөтөлбөрийн хөрөнгө оруулалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон нутгийн бизнес эрхлэгчдийг чадавхжуулна.	-	Төсөл, хөтөлбөр гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдсэн эсэх	-	Төсөл, хөтөлбөр гадаадын хөрөнгө оруулалт нэмэгдүүлнэ	Арабын Хөгжлийг Дэмжих Күвейтийн Сангийн хөрөнгө оруулалтаар Өндөрхаан нисэх буудлын хөөрч буух зурвасын барилгын ажил хийгдсэн ба барилгын ажлын явц 85%-тай үргэлжилж байна. Дэлхийн банкны 6,9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Бор-Өндөр, Хэрлэн сумдын цахилгаан түгээх сүлжээг шинэчлэх ажлын гэрээ байгуулагдаж ашиглалтад оруулахад бэлэн болсон байна.	90%
37		4.1.4. Төрийн худалдан авах ажиллагаагаар дамжуулан дотоодын үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний худалдан авалтыг дэмжиж, тогтвортой нэмэгдүүлнэ.	-	Нийт худалдан авалтад дотоодын үйлдвэрлэлээс авсан бараа, бүтээгдэхүүний хувь	9,6%	-	Сумдын Засаг дарга нарын 2022 оны гэрээнд холбогдох заалтуудыг тусгаж ажилласан. Мөн засгийн газрын 90 тогтоолын дагуу чанар стандартын шаардлага хангасан 4,070.7 сая төгрөгийн дүн бүхий бараа, бүтээгдэхүүнийг аймгийн хэмжээнд худалдан авсан байна.	90%

38	4.2. Эдийн засгийн чиглэл	4.2.1. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг өсгөж, малын гаралтай бүтээгдэхүүний үйлдвэрүүдийг барьж, экспортыг нэмэгдүүлнэ.	-	үйлдвэр баригдсан эсэх	1 ноос боловсруулах үйлдвэр ажиллагаа явуулдаг. үйл	малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрүүдийг барьсан байна.	<p>Дадал суманд үржүүлж буй Мах-сүүний хосолмол ашиг шимтэй дадлын ухаа үхрийг “Дадалын ухаа” үүлдрээр батлуулсан. ОНТөсвийн 12.8 сая төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үүлдэр омгийн 7.2 мян.тол малд үзлэг ангилт хийж, 790 толгой малыг ээмэгжүүлж, бүртгэлжүүлсэн. Ангилалтад хамрагдсан нийт малын 33.0%-г цөм сүрэгт, 55.7%-г үржлийн сүрэгт, 11.3%-г хэрэгцээний сүрэгт тус тус бүртгэсэн. Улсын төсвийн 37.5 сая төгрөгийн хөрөнгөөр Батширээт, Дадал, Батноров, Норовлин сумдын 41 өрх, 2 аж ахуйн нэгжийн 267 үнээнд Герефорд, 180 үнээнд Ангус, 280 үнээнд Симменталь үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үрээр, нийт 727 үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн. Мөн Баян-Овоо суманд бага оврын үйлдвэрийн барилгын ажил 85%-тай үргэлжилж байна.</p>	100%
----	---------------------------	---	---	------------------------	---	--	---	------

39		<p>4.2.2. Аймгийн онцлог бүхий аялал жуулчлалыг хөгжүүлж, аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн бий болгох замаар олон улсын аялал жуулчлалын зах зээлээс жуулчид татаж, зорин ирэх жуулчдын тоог өсгөнө.</p>	-	<p>жуулчдын өссөн эсэх тоо</p>	<p>дотоодын жуулчид 48,6 мянга</p>	<p>Гадаад, дотоодын жуулчдын тоо өссөн байна.</p>	<p>Хэнтий аймгийн төвд Аялал жуулчлалын мэдээллийн төв, Жаргалтхаан суманд авто замын дагуу түр буудаллах цэг, аялал жуулчлалын мэдээллийн төв тус тус байгуулагдаж, жилдээ 11,0 мянга гаруй иргэдэд үйлчилгээ үзүүлж ажиллаж байна. 5-6 эвент арга хэмжээг тогтмол зохион байгуулж байгаа ба 7 хэл дээр орчуулагдан welcometomongolia сэтгүүл болон элчин сайдын яамдаар дамжуулан олон улсад сурталчлагдаж байна. 2021 оны суурь түвшинтэй харьцуулахад гадаадын жуулчин 50 гаруй хувь, дотоодын жуулчдын тоо 36.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.</p>	100%
40		<p>4.2.3. Эдийн засгийн хөгжлийг дэмжсэн эрчим хүч, инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлнэ.</p>	-	<p>гүйцэтгэлээр</p>	-	<p>Инженерийн дэд бүтцийг нэмэгдүүлсэн байна.</p>	<p>"Эрчим хүчний яамны захиалгаар Дэлхийн банкны эрчим хүчний төсөл-2" 95 хувьтай хэрэгжиж байгаа бөгөөд тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажлыг хийж гүйцэтгээд 2024 ондоо багтаан байнгын ашиглалтад оруулахаар төлөвлөж байна. Хэрлэн сумын гэр хорооллыг хөгжүүлэх чиглэлээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1, 2 дугаар багийн 2300 өрхийг инженерийн шугам сүлжээнд холбох ажлыг Комфорт Импэкс ХХК, Солармед Монгол ХХК нар ариутгах татуургын нийт 15.6 км шугам, дулаан цэвэр усны 13 км шугамын угсралтын ажил гүйцэтгэсэн байна. Гүйцэтгэлийн хувь 95.5%-тай үргэлжилж байна .</p>	100%

41	4.2.4. Жоншны баяжмал, шууд ангижруулсан төмрийн үйлдвэрийн бүтээн байгуулалтыг эхлүүлж, ашиглалтад оруулах, түүнд шаардлагатай дэд бүтэц болох авто зам, ус, эрчим хүчний төслүүдийг Бор-Өндөр, Дархан сум, Бэрх тосгоныг түшиглэж хэрэгжүүлнэ.	-	хэрэгжсэн эсэх	-	Төслийн ТЭЗҮ хийгдсэн байна.	Бор-Өндөр суманд хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 400.0 мянган тонн төмөр үйлдвэрлэх хүчин чадалтай үйлдвэр барих төслийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулагдаад байна. Бор-Өндөр Уулын баяжуулах үйлдвэр нь цайр шинээр боловсруулах дэвшилтэт технологийг нэвтрүүлэхээр туршилтын үйл ажиллагаа явуулж байна.	100%
42	4.2.5. Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станцыг барьж, цахилгаан эрчим хүчний хангалтыг өсгөнө.	-	-	6200 нэгж талбар ЦЭХ-ээр хангагдаагүй байна.	Шинэ суурьшлын бүсийг үе шаттай ЦЭХ-ээр хангана.	Улсын төсвийн 650 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Дадал, Норовлин, Баянхутаг, Өмнөдэлгэр, Батширээт, Хэрлэн сумдад, ОНХС-ийн 150 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар, Дадал, Цэнхэрмандал сумын Хужхан баг, Баян-Овоо, Батноров, Дэлгэрхаан, Хэрлэн сумдад шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангах ажил бүрэн хийж дуусгалаа.	100%
43	4.2.6. Зүүн бүсийн логистикийн төвийг төр, хувийн хэвшлийн түншлэлээр байгуулна.	-	Хэрэгжилтээр	-	-	Монгол шуудан ХХК-тай хамтарч зүүн бүсийн тээвэр, логистикийн байгууламж барих эскиз зурагт санал солилцож аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулж Аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлж шийдвэрлүүлэн батлуулахаар хэлэлцэж байна.	30%
44	4.2.7. Улаанбаатар-аймаг-сум хоорондын нислэгийн чиглэл, тоог нэмэгдүүлнэ.	-	Гүйцэтгэлээр	Өндөрхаан нисэх буудлын зурвасын ажлын гүйцэтгэл 50%,	Өндөрхаан нисэх буудлын барилгын ажил үргэлжилнэ. Дэлүүн Болдог нисэх буудлын барилга ашиглалтад орно.	Өндөрхаан нисэх буудлын зурвасын ажил 100% дууссан, барилга угсралтын ажил 80 хувь, Дэлүүн Болдог нисэх буудлын барилгын явц 80 хувьтай ажил үргэлжилж байна.	70%

45		4.2.8. Түүхэн аялал жуулчлалын бүс нутгийн сумд руу авто зам барина.	УТХО 45000.0	Гүйцэтгэлээр	Чингис хот-Бэрх 20 км хатуу хучилттай авто зам баригдсан.	Чингис хот-Бэрх 50 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орно.	Чингис хотоос Бэрх тосгон хүртэл 70 км хатуу хучилттай авто зам ашиглалтад орсон. 2023 онд Бэрх тосгон Батноров сум хүртэл 35 км автозам ашиглалтад орсон байна.	100%
46	4.3. Санхүүгийн систем	4.3.1. Бичил санхүүгийн байгууллагуудыг чадавхжуулан эрсдэлийн удирдлагыг сайжруулж, үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	-	Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжсэн эсэх.	-	Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаа идэвхжсэн байна.	Бичил санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор 2 удаагийн сургалт зохион байгуулж, бичил санхүүгийн үйл ажиллагаа эрхэлдэг ХЗХоршооны үндсэн-1, салбар-4, ББСБайгууллагын үндсэн-3, салбар-8 -ыг тус тус хамрууллаа. Бичил санхүүгийн байгууллагуудад цахим зээлийн үйлчилгээг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна.	90%
47		4.3.2. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ.	-	Хэрэгжүүлсэн эсэх	-	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх ажиллагааг орон нутагт хэрэгжүүлнэ.	Банкны салбаруудын ажилтнууд болон албан байгууллагуудаар Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн сургалтыг зохион байгуулж арилжааны банкуудад сэрэмжлүүлэг хүргүүлэн ажиллаж байна. Цахим гэмт хэрэг, залилангаас урьдчилан сэргийлэх зорилгоор Монголбанк, ЦХХХЯам, Цагдаагийн газартай хамтран ажиллаж иргэдэд сурталчилж , сэрэмжлүүлгийг тухай бүрт хүргэж ажилласан.	90%



48		4.3.3. Банкны салбаруудын орон нутгийн байгууллагуудын уялдааг хангаж, иргэдэд найдвартай, шуурхай, хөнгөлөлттэй үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг сайжруулна.	-	Банкны салбаруудын үйлчилгээ үзүүлэх нөхцөл сайжирсан эсэх.	-	Банкны салбаруудын үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг нэмэгдүүлэх	Хэнтий аймаг дахь арилжааны банкнууд салбар нэгжээрээ дамжуулан Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй " Хүнсний болон ХАА-н үйлдвэрлэлийг дэмжих 5-6 хувийн хүүтэй газар тариалан, мал аж ахуйн хөнгөлөлттэй зээлд 23 иргэн, ААН хамрагдаж 3584.9 сая төгрөгийн зээл олгогдсон. Ипотекийн 3%-ийн 3368.8 сая.төгрөгийн зээлийг 44 иргэнд , 6%-ийн 1566.3 сая.төгрөгийн зээлийг 22 иргэнд тус тус олгосон. Мөн иргэдэд үзүүлэх үйлчилгээний нөхцөлийг сайжруулах зорилгоор Хас банк дижитал банкны системд шилжсэн, Төрийн банк банкны аппликэшнаа шинэчлэн онлайн зээлийн бүтээгдэхүүнийг гаргаж иргэдэд үйлчилж байна.	90%
49	4.4. Бүс нутгийн хамтын ажиллагаа	4.4.1. Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улс болон гуравдагч орнуудтай худалдаа, нийгэм, эдийн засгийн харилцааг өргөжүүлж, экспортыг дэмжих, арга хэмжээ авна.	-	хамтран ажилласан байдал	-	-	Орос - Украйны дайнтай холбогдуулан ОУ эдийн засгийн нөхцөл байдал хүнд байгаач 2023 оос эхлэн ОХУ-ын Өвөрбайгалийн хязгаартай харилцаа холбоо сэргэж эхэлсэн. Бүгд Найрамдах Киргиз Улсын Чуй мужтай хамтын ажиллагааны гэрээ байгуулсан.	100%
50	4.5. Хэнтийн брэнд бүтээгдэхүүн	4.5.1. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлж, шинэ санаа, оюуны бүтээл, дэвшилтэт техник, технологид тулгуурлан Хэнтийд үйлдвэрлэсэн эрүүл чанартай бүтээгдэхүүний Брендийг бий болгон, гадаад дотоодын зах зээл дахь	-	Ажлын гүйцэтгэлээр	17 сум,1 тосгоны нийт 170 иргэн 100 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр үзэсгэлэн худалдаанд оролцож 10 төрлөөр шилдэг брэнд бүтээгдэхүүн шалгаруулан нийт 102,6 сая	10-аас дээш шилдэг бүтээгдэхүүнийг шалгаруулж ажилласан байна.	2023 онд Бизнес Инкубатор төв шинээр бий болж, тус төвүүдэд 2 аж ахуйн нэгж, 7 иргэн бойжиж байна. БИТ-н 3 бойжигчийг Хоршоо хөгжүүлэх сангаас 75.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан. Best хөтөлбөрийн тэтгэлэгт сонгон шалгаруулалтаас 1 аж ахуйн нэгж 10 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэгт шалгарч үйл ажиллагаагаа явуулж байна. Мөн 11-н шилдэг бүтээгдэхүүн шалгаруулж урамшуулал олгосон.	50%

		борлуулалтын сүвгийг тэлнэ.			төгрөгийн борлуулалт хийгдсэн.			
<b>5. ТАВ. ЗАСАГЛАЛ</b>								
51	5.1. Цахим Монгол	5.1.1. "E Mongolia" болон "erp.e- mongolia" системийг аймгийн хэмжээнд үе шат дараатайгаар нэвтрүүлж төрийн үйлчилгээг шуурхай, чирэгдэлгүй хүргэж, ил тод байдлыг хангана.	-	Биечлэн үйлчилгээ авсан иргэдийн хувь	2019 онд төрийн байгууллагаар биечлэн үйлчлүүлсэн иргэд /давхардсан тоогоор/ 316740	Биечлэн үйлчилгээ авсан иргэдийн тоо 10 хувиар буурсан байна	E-mongolia системийн ашиглалтын талаар видео сургалтыг цахим орчинд, иргэнд шууд үйлчилгээ үзүүлдэг 8 байгууллага, E-mongolia сурталчлах цэг, 88 багийн иргэдийн нийтийн хурлаар 2 удаа иргэд олон нийтэд сурталчлан таниулсан. Мөн 8 байгууллагын 71 үйлчилгээ, аймгийн ЗДТГ-аас олгодог 4 тусгай зөвшөөрлийг цахимжуулсанаар төрийн үйлчилгээг биечлэн авсан иргэдийн тоог 16 хувиар бууруулсан.	100%
52	5.2. Чадварлаг, ёс зүйтэй төрийн алба	5.2.1. "Иргэн төвтэй төрийн үйлчилгээ" арга хэмжээг хэрэгжүүлэх замаар төрийн үйлчилгээний чанар, төрийн албан хаагчийн мэдлэг, чадвар, ёс зүй, сахилга, хариуцлагыг сайжруулна.	-	төрийн албан хаагчтай холбоотой ирсэн өргөдөл гомдлын тоо	төрийн албан хаагчтай холбоотой ирсэн өргөдөл гомдлын тоо 20	төрийн албан хаагчтай холбоотой ирсэн өргөдөл гомдлын тоог өмнөх оноос 50 хувиар буурсан байна.	Иргэдэд биечлэн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын албан хаагчдад тулгуурлан сурталчлан таниулах ажлыг зохион байгуулж байгууллагуудад сар, улирал тутам ёс зүйн мэдээ тайлан авч, хяналт тавьж ажиллаж байна. Энэ онд 3 өргөдөл гомдол ирсэн ба өмнөх жилээс 50% буурсан байна.	100%
<b>6. ЗУРГАА. НОГООН ХӨГЖИЛ</b>								
53	6.1. Эх байгаль, экосистем	6.1.1. Тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эхийг улсын тусгай хамгаалалтад авах ажлыг эрчимжүүлнэ.	-	нийт нутаг дэвсгэрт ТХГН- ийн эзлэх хувиар	43,03	46	Ус бүрэлдэх эх болон экосистемийн ач холбогдол бүхий Өмнөдэлгэр сумын Тэнүүн гол орчмын 119.9 мянган га газрыг орон нутгийн тусгай хамгаалалтад авснаар, нийт нутаг дэвсгэрийн 46.3%-ийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар эзэлж байна.	100%

54		6.2.1. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс сэргийлэн, эвдрэлд орсон, доройтсон газрыг нөхөн сэргээж, аж ахуйн эргэлтэд оруулна.	БХНСЗ 10,0	га талбайгаар	20 га	10 га талбайд нөхөн сэргээсэн байна.	ОНТ-ийн БХНСЗардлаар Цэнхэрмандал сумын Хэрлэнгийн гүүр нэртэй уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн 10 га талбайд, Хэрлэн суманд дулааны энгэр нэртэй 1.2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийсэн. Батноров, Хэрлэн, Норовлин, Өмнөдэлгэр сумдад баригдаж буй авто замын засвар, бүтээн байгуулалтын ажилд ашиглагдаж эвдэрсэн 117.5 га замын карьерын талбайд нөхөн сэргээлтийг хийлгээд байна. Уул уурхайн аж ахуйн нэгжийн дүйцүүлэн хамгаалах ажлын хүрээнд 1.4 га талбайн нөхөн сэргээлтийн ажлыг хүлээж авсан.	100%
55	6.2. Байгалийн баялгийн өгөөж	6.2.2. Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээж, ашиглалтад өртөмтгий амьтан, ургамлыг зориудаар үржүүлэн тарималжуулж ашиглалтын нөөц бий болгоно.	БХНСЗ 10,0	тоогоор	50 толгой “Монгол тарвага” нутагшуулсан.	Тураг гогойн тархац нөөц, тоо толгойн судалгаа хийнэ.	Хэнтий аймгийн нутагт байрлаж буй томоохон гол, нууруудад тураг гогой шувууны байршил, тархалтад тандалт судалгаа хийх ажлыг 5 болон 10-р саруудад 2 удаа зохион байгуулсан. Хэрлэн гол, Онон гол болон загасны нөөц бүхий томоохон Хангал, Ёл нуур, агнуур зохион байгуулалт, менежмент төлөвлөгөөнд тусгагдсан загасны нөөц бүхий цэгүүдэд 11 ширхэг хөдөлгөөнт камер байрлуулж, дрон нисгэж тандалт судалгаа хийсэн. 5 сард 679 орчим, 10 сард 250 орчим тураг гогой шувуу тоологдлоо. Тус судалгаагаар 12 сумын нутагт Дэрвэгэр жиргэрүү ургамлын тархац бүртгэгдсэн бөгөөд үүнээс Биндэр суманд ашиглалтын /80 га талбайд биологийн нөөц 5.3 тн, ашиглалтын нөөц 0.53 тн, жилд ашиглах 0.05 тн/ байгалийн нөөцтэй гэж тодорхойлогдсон. Хэрлэнбаян-Улаан тосгонд тус ургамлыг 50 га талбайд тарималжуулж байна.	100%

56		6.2.3. Ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ.	-	га талбайгаар	Ойжуулалтын ажлыг 150 га талбайд хийсэн.	Ойжуулалтын ажлыг 250 га талбайд хийсэн байна.	Улсын төсвийн хөрөнгөөр Дадал, Баян-Адарга сумдад нийт 90 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажил, ой бүхий 6 сумдад Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон ойн мэргэжлийн байгууллагын өөрийн хөрөнгөөр нийт 212 га талбайд ойжуулалтын ажил тус тус зохион байгуулж, нийт 302 га талбайд ойг нөхөн сэргээж, ойжууллаа. Нийт ойн сангийн хэмжээг 0.04 хувиар нэмэгдүүллээ.	100%
57	6.3. Ус үнэт баялаг	6.3.1. Усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулж, усны бохирдол, хомсдолыг бууруулна.	БХНС3 7.5	тоогоор	4 ширхэг тэмдэг тэмдэглэгээ хийж байршуулсан.	30-аас доошгүй тэмдэгжүүлэлт хийгдсэн байна.	Онон-Улз, Хэрлэн, Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газруудад усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсэд дэглэмийг мөрдүүлэх зорилгоор нийт 60 ш тэмдэгжүүлэлт хийж байршуулсан.	70%
58		6.3.2. Газрын байгалийн тогтоц, голын татамд хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах хөв цөөрөм, далд усан сангууд байгуулна.	БХНС3 10,0	тоогоор	Цэнхэрмандал сумын Цэнхэрийн гол дээр 59000м3 ус хурах талбай бүхий хөв шинээр байгуулсан.	1 хөв цөөрөм сэргээн засварласан байна.	Дархан сумын хөвийг сэргээн засах зорилгоор зураг төсвийн ажлыг гэрээгээр Гидрофонтан ХХК гүйцэтгэсэн. Хэрлэн сумын Хэрлэн голын эрэг дэх хөв цөөрмийн 1.8 км далангийн ажлын хэлбэржүүлэлтийг "Эм Ди Юу" ХХК гэрээгээр хийж гүйцэтгэсэн.	100%

59		6.3.3. Саарал усны технологийг ахуйн хэрэглээнд нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, эхлүүлнэ.	ОНТ 500.0	Хувиар	-	Саарал хэрэглээнд нэвтрүүлэх нөхцөлийг бүрдүүлж, эхлүүлнэ.	Аймгийн хэмжээнд хийгдэж байгаа сумдын инженерийн байгууламж, бохир ус зайлуулах, цэвэрлэх байгууламжийг шинээр барих ажлын төлөвлөлтөд саарал усны технологийг судлан нэвтрүүлэх бодлого барьж ажилласнаар бохир усыг 95-98%, цэвэрлэх технологи бүхий Дадал, Норовлин суманд 50 м3/х хүчин чадалтай цэвэрлэх байгууламж ашиглалтад орсон. Ингэснээр саарал усыг ахуйн хэрэглээнд нэвтрүүлэх нөхцөл боломж бүрдээд байна.	50%
60	6.4. Нүүрстөрөгч багатай, бүтээмжтэй, хүртээмжтэй ногоон хөгжил	6.4.1. Ус, цаг уурын ажиглалтын болон орчны хяналт-шинжилгээний сүлжээг өргөжүүлж, цаг агаарын аюулт үзэгдлийг урьдчилан мэдээлэх, сэрэмжлүүлэх чадавхыг бэхжүүлж байгалийн гамшгийн эрсдэлийг бууруулна.	АЗДНС-ийн Гамшгийн эрсдлийг бууруулах сан 10.0	үйл ажиллагаагаар	18 сумыг 100 хувь автомат станцтай болгосон.	Цаг агаарын нөхцөл бүрдсэн үед тунадасны хэмжээг нэмэгдүүлж ажиллана.	2023 онд 8 удаагийн процесст 2 хөдөлгөөнт экспецици 14 удаа цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэн ажилласан. Дулааны улиралд аймгийн ихэнх нутгаар хур тунадас олон жилийн дунджаас ахиу тунадас орсон. Хэрлэн, Өлзийт, Хурх тосгон орчмоор дунджийн орчим хур тунадас орсон. ЦУОШГ-аас цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг" үр дүн сайтай ажилласан гэж дүгнэгдсэн. Тунадасны хэмжээг 21.8%-иар нэмэгдүүлсэн .	100%
61		6.4.2. Аймгийн хэмжээнд ногоон худалдан авалтыг нэмэгдүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувиар	-	Ногоон худалдан авалтыг дэмжинэ.	2023 оны байдлаар аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 297 төсөл арга хэмжээний урилга, үр дүн Төрийн худалдан авах ажиллагааны цахим системд <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> сайтад нийтлэгдэж Хэнтий аймгийн хэмжээнд төсөл арга хэмжээг 100% цахимаар зарлаж байна. Хуванцар, гялгар уутыг дахин боловсруулж пластик үйлдвэрлэдэг аж ахуйн нэгжээс Төв цэнгэлдэх хүрээлэн болон наадмын морь барианы газарт суурилуулах бохирын цооногийн ёмкост 3 ширхгийг худалдан авч ногоон худалдан авалтыг дэмжсэн.	100%

62		6.4.3. Аймгийн болон сумын төвүүдийн хог хаягдлын асуудлыг шийдэж, хог дахин боловсруулах үйлдвэрийг барьж эхлүүлнэ.	-	үйл ажиллагааны хэрэгжилтээр	Хэрлэн суманд хогны менежмент хэрэгжүүлсэн.	2-оос доошгүй суманд хогны менежментийг хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн байна.	17 суманд хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, шатаах зэрэг 36 техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн. Дадал суманд АХБанкны санхүүжилтээр хог хаягдлын 2-р зэргийн ландцил төвлөрсөн цэг ашиглалтад орж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаад байна. Хэрлэн сумын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор 2тн/хоног хүчин чадалтай хог хаягдал шатаах зуух худалдан авч, Чингис дагуу дахивар хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах зорилготой цэгийг байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж тохижуулсан. Чингис хот, Бор-Өндөр суманд хуванцар, шил, лааз, гялгар уут, хайлш, цаас зэрэг дахивар хог хаягдлыг ангилан ялгаж преслэн, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлж, хаягдал цаасаар шахмал түлш үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж, 74.6 тн хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулан хаягдлын хэмжээг 30 хувиар бууруулаад байна.	100%
----	--	--	---	------------------------------	---	--	---	------

7. ДОЛОО. АМАР ТАЙВАН, АЮУЛГҮЙ НИЙГЭМ

63	7.1. Зэвсэгт хүчин, гамшгийн эрсдэлийг бууруулах	7.1.1. Мэргэжлийн, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, алба хаагчдын амьдрах нөхцөл шинэчлэгдэж, хугацаат цэргийн алба хаагч иргэдийн хувийг нэмэгдүүлнэ.	-	Хугацаат цэргийн албанд татагдсан иргэдийн тоогоор	-	Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар ирүүлсэн хяналтын тоог биелүүлсэн байна.	2023 оны 1, 2 дугаар ээлжээр ЗХЖШ-ын даргын тушаалаар батлагдсан хяналтын тоог 100 хувь биелүүлж Зэвсэгт хүчний болон Хилийн цэргийн анги, байгууллагад цэргийн албыг хаалган ажиллаж байна.	100%
64		7.1.2. Орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бэхжүүлж, дайчилгааны төлөвлөлтийг хэрэгжүүлнэ.	-	Хэрэгжилтийн хувиар	Улсын болон цэргийн дайчилгааны төлөвлөгөөг боловсруулж ЗХЖШ-ын даргаар	Цэргийн дайчилгааны болон орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөг тогтоосон	Цэргийн дайчилгааны төлөвлөгөөг ЗХЖШ-аас гаргасан дайчилгааны зааварт тусгасан хуваарийн дагуу 5, 11 дүгээр саруудад Зэвсэгт хүчний 327, 232 дугаар ангиудтай хүн, техникт тодотгол явуулж ажилласан.	100%

					батлуулж орон нутагт хэрэгжүүлэн ажиллаж байна.	хугацаанд тодотгож ажиллах		
65		7.1.3. Гамшгийн техник хэрэгсэл, туулах чадвартай автомашин хангалтыг нэмэгдүүлнэ.	120	Гамшиг осолтой тэмцэх бэлэн байдлаар	-	Гамшиг осолтой тэмцэх бэлэн байдал дээшилсэн байна.	Засаг дарга Онцгой байдлын газрын албан хэрэгцээнд зориулж гал унтраах тусгай зориулалтын 40 сая төгрөгийн өртөгтэй Nissan safari маркийн автомашин, 100 ширхэг ажлын хувцасны хамт хүлээлгэн өгсөн.	100%
66		7.1.4. Гамшгийн аюулын үед харилцан ажиллах дадлага, сургуулилтыг нэмэгдүүлэх, иргэдэд гамшиг аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлнэ.	5	Гамшиг осолтой тэмцэх бэлэн байдлыг хангуулах	-	Гамшиг осолтой тэмцэх бэлэн байдлыг хангуулах	Радио станц, нисгэгчгүй нисэх төхөөрөмж, иридиум утсыг шинээр авч бэлтгэл бэлэн байдлыг хангуулсан нь эрэн хайх, аврах ажиллагаа болон гамшгийн голомтод холбоо зохион байгуулах боломжийг сайжруулан холбооны техник хэрэгслийн хүчин чадал өмнөх оны мөн үеэс 5%-иар нэмэгдсэн.	100%
67	7.2. Хүн, нийгмийн амар тайван байдал	7.2.1. Архидан согтуурахтай хийх тэмцлийг эрчимжүүлж, архинд донтох эмгэгтэй хүнд үзүүлэх эмчилгээ, үйлчилгээний үндэсний чадавхыг бэхжүүлж, архидан согтуурахтай тэмцэх сангийн үр өгөөжийг нэмэгдүүлж “Архидалтгүй Хэтийн Хэнтий” арга хэмжээг зохион байгуулна.	-	Эмийн болон албадан эмчилгээнд хамрагдсан хүний тоо	10 хувь буюу 5 хүнийг эмийн болон албадан эмчилгээнд хамруулж, урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулсан байна.	10 хувь буюу 5 хүнийг эмийн болон албадан эмчилгээнд хамруулж, урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулсан байна.	Архидалтгүй хэтийн Хэнтий арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд “Хэрлэнгийн цэнхэр алс” ТББ, “Өндөрхаан Оршихуй” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллан хорт зуршлаасаа өөрийн хүсэлтээр ангижрах хүсэлт гаргасан 24 хүнийг эмийн эмчилгээнд, 1320 иргэнийг сургалтад хамруулсан байна.	100%

68		7.2.2. Иргэд гэр бүлдээ амар тайван, аюулгүй амьдрах орчин нөхцөлийг олгох, гэр бүлийн хүчирхийллийг бууруулах, хүүхдийн аюулгүй амьдрах орчныг бүрдүүлнэ.	-	Хамрагдсан иргэдийн тоогоор	4 удаагийн нөлөөллийн ажилд 5262 иргэн, гэр бүлийн боловсрол олгох сургалтыг 14252 иргэнд хийсэн	Урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагаа 6 удаа зохион байгуулж, нийт иргэдийн 20 хувийг сургалтад хамруулна.	Жендерийн тэгш байдлыг хангах, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх чиглэлээр нөлөөллийн 14 удаагийн үйл ажиллагаа зохион байгуулсан. Гэр бүлд боловсрол олгох, Сэтгэл зүйн боловсрол олгох модуль сургалтуудыг 18 сум 1 тосгонд 230 удаа зохион байгуулж нийт 28807 иргэн буюу нийт иргэдийн 36.2%-ийг хамруулсан.	100%
69	7.3. Хууль сахиулах салбарын хөгжил	7.3.1. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтыг нэмэгдүүлж, төв магистрал зам дагуу тээврийн хэрэгслийн бүртгэлжилт хурдны дундаж тодорхойлох хяналтын камер байрлуулан нэгдсэн системд холбож, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх нөхцөлийг сайжруулна.	-	Хяналтын камертай сумдын хувиар	15 сум сумдын хяналтын камертай байна	Тухайн жилд 139 камерт засвар үйлчилгээг хийсэн байна.	2023 онд Авид хайрхан ХХК-тай гэрээ байгуулан нийт 139 камерт засвар үйлчилгээ хийлгэж, мөн аж ахуй нэгжийн хяналтын камерыг нэгдсэн сүлжээнд холбох ажлыг 5 сая төгрөгөөр гүйцэтгэсэн.	100%
70		7.3.2. Шүүхийн шинжилгээний байгууллагын ажиллах нөхцөлийг сайжруулж, чадавхыг дээшлүүлэн, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.	35	Цогцос зөөвөрлөх чиргүүлтэй болсон байх	-	Шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмж метал хайгчтай болсон байна	Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн өдрийн А/575 дугаар захирамжаар Шүүхийн шинжилгээний хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж авахад зориулж 9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.	100%
71		7.3.3. Мал хулгайлах гэмт хэргийг бууруулна.	-	Мал хулгайн гэмт хэргийн тоогоор	124	Мал хулгайлах гэмт хэрэг буурсан байна.	Аймгийн ГХУСАЗСЗ-өөс "Эзэнтэй мал" арга хэмжээний төлөвлөгөө батлан 100 хувь хэрэгжүүлсний хүрээнд мал хулгайлах гэмт хэрэг өмнөх онтой харьцуулахад 23.7 хувиар буурсан дүнтэй байна.	100%

8. НАЙМ. БУС, ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛ



72	8.1. Дэд бүтэц	8.1.1. Байгаль орчинд ээлтэй, эрэлтэд нийцсэн, тогтвортой, хүртээмжтэй, аюулгүй тээврийн үйлчилгээг хөгжүүлж, авто замын сүлжээг өргөтгөнө.	45,000.0	Ажлын гүйцэтгэлээр	Чингис хотоос Дадал хүртэлх 20 км авто зам баригдсан.	Чингис хот-Дадал чиглэлд хатуу хучилттай авто замын ажил үргэлжилнэ.	Бэрх тосгоноос Батноров хүртэл хатуу хучилттай авто замын ажил 100% хийгдсэн бөгөөд Норовлин чиглэлийн 131 км хатуу хучилттай авто замын 75 км далангийн дүүргэлт нягтруулгын ажил үргэлжилж байгаа ба 18 км өнгө болон суурь асфальтбетоны хучилтын ажил, 9 цэгт дугуй хоолойн угсралт, 1 цэгт гүүрний ажил хийгдээд байна ажлын гүйцэтгэл 20 хувь. Мөн Жаргалтхаанаас Өмнөдэлгэр сумыг холбосон 52.5 км хатуу хучилттай авто замын ажил 85 хувьтай байна.	100%
73		8.1.2. Орон нутгийн болон цаг агаарын урьтаж анхааруулах мэдээг малчдад дамжуулж бэлэн байдалд оруулах, мэдээлэл холбооны эргэх холбоо бүхий системийг аймгийн төв болон сумдад үе шаттайгаар байгуулна.	-	Цаг агаарын мэдээ хүргэсэн эсэх	-	цаг агаарын мэдээллийг тогтмол хүргэж, болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлж ажилласан байна.	Цаг агаар урьдчилсан мэдээг 18 сум 5 тосгоны 3895 иргэнд 9 удаагийн давталтаар нийт давхардсан тоогоор 35055 иргэнд хүргэсэн байна. Цахим мэдээллийн 3 хуудсаар дамжуулан 31,6 мянган иргэнд, автомат хариулагч утсанд 9864 иргэн хандаж мэдээлэл авсан байна.	100%
74		8.1.3. Орон нутгийн нисэх буудлын хүчин чадлыг сайжруулж, үйл ажиллагааг өргөжүүлж, агаарын тээврийн үйлчилгээг жигдрүүлнэ.	-	Ажлын гүйцэтгэлээр	"Дэлүүн болдог" нисэх буудлын хөөрч. буух зурвасын ажлыг гүйцэтгэсэн. "Өндөрхаан" нисэх буудлын хөөрч. буух зурвасын ажил гүйцэтгэх гэрээ байгуулагдсан.	"Дэлүүн болдог", "Өндөрхаан" нисэх буудлын барилгын ажил дуусна.	Өндөрхаан нисэх буудлын зурвасын ажил 100% дууссан, барилга угсралтын ажил 80 хувь, Дэлүүн Болдог нисэх буудлын барилгын явц 80 хувьтай ажил үргэлжилж байна.	70%
75		8.1.4. Аялал жуулчлал, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл төвлөрсөн зарим сумдын төвүүдэд чиглэсэн хөрөнгө	-	Хөрөнгө оруулалтын хэмжээгээр	аймгийн хөрөнгө оруулалтаар түүхэн аялал жуулчлалын сумын төвүүдэд нийт 758.5 сая	Аялал жуулчлал, хөдөө аж ахуй, үйлдвэрлэл төвлөрсөн зарим сумдад чиглэсэн хөрөнгө	Дадал суманд "Исун мод тур" ХХК-ны хөрөнгө оруулалтаар Дотоод, гадаадын жуулчдад зочид буудал, зоогийн газрын үйлчилгээг олон улсын стандартын түвшинд хүргэх, орон нутагт шинээр ажлын байр бий болгох,	100%

	оруулалтын хэмжээг нэмэгдүүлж, давуу талд тулгуурлан бүсчилж хөгжүүлнэ.			төгрөгийн санхүүжилт хийсэн.	оруулалтын хэмжээг нэмэгдүүлсэн байна.	тогтвортой аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах үйл хэрэгт хувь нэмэр оруулах зорилгоор байгаль орчинд ээлтэй, эко жуулчны баазыг олон улсын стандартын түвшинд нийцүүлэн байгуулж байна. Хэрлэн сумын Өлзийт тосгонд "М-агро" ХХК-ны хөрөнгө оруулалтаар эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж, экспортын шаардлага хангасан мах махан бүтээгдэхүүн үйлдвэрлэх, бэлчээрийн доройтлыг бууруулах дэвшилтэт технологи бүхий Хөдөө аж ахуйн цогцолбор парк төслийг хэрэгжүүлж байна.	
76	8.1.5. Хот хоорондын болон орон нутгийн нийтийн тээвэр, шуудан үйлчилгээний хүрээг тэлж, чанар хүртээмжийг сайжруулж, иргэдийн тав тухтай үйлчлүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.	-	Орон нутгийн зорчигч тээврийн замнал нэмэгдсэн.	Бор-Өндөр сумын чиглэлд орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээ хийж байна..	Хот хоорондын болон орон нутгийн нийтийн тээврийн хамрах хүрээг өргөтгөнө.	2023 оны Эрдэм Транс ХХК нь Батноров сум-Улаанбаатар-До.Баян-Уул чиглэлд тус тус дамжин өнгөрөх тээвэрлэлт гүйцэтгэж байна. Улаанбаатар-Бор-Өндөр-Улаанбаатар чиглэлд тээвэрлэлт гүйцэтгэхээр бэлтгэл ажил явагдаж байна.	100%
77	8.1.6. Шилэн кабелийн сүлжээг өргөтгөж, интернэт, IPTV хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлнэ.	-	Шилэн кабел холбогдсон сум тосгодын тоогоор	18 сум 2 тосгон шилэн кабельд холбогдсон.	Шилэн кабелийн хамрах хүрээг өргөтгөнө	2023 онд Unitel Group нь чингис хотын 2,3,4-р багт өргөтгөл хийж ажилласан. Мөн Үүрэн холбооны G mobile ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан шаардлагатай цэгт интернетийн үйлчилгээг сайжруулах ажлыг хийж байна. 5 сумын төвийг шилэн кабелийн сүлжээнд өргөтгөлийн ажил хийгдсэн байна.	100%

78		8.1.7. Аймгийн хэмжээнд хаягжуулалт, газар зүйн нэрийн тодруулгын ажлыг хэрэгжүүлж, мэдээллийн нэгдсэн санг бий болгоно.	-	-	10 суманд хаягийн тэмдгийг суурилуулах ажил хийгдсэн	-	Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг стандартын дагуу хаягжуулах ажлын хүрээнд энэ онд Дархан сумын хаягийн тэмдэг суурилуулах ажлыг гүйцэтгэсэн. Мөрөн сумын хаягжуулалтын ажил дууссан. Өмнөдэлгэр, Дадал сумдын газар зүйн нэрийн тодруулалтын ажлын байрзүйн зураг, Газар нутгийн нэрийн зурагтай харьцуулан зураглан хээрийн хэмжилт судалгааг хийж, ажлын явц 85% байна.	90%
79		8.1.8. Бүсийн аймгуудын үйлдвэрлэл эрхлэгчдийн уялдаа холбоог хангаж, хамтын ажиллагааг дэмжинэ.	-	гүйцэтгэлээр	-	бүсийн аймгуудын үйлдвэрлэл эрхлэгчдийн хамтын ажиллагаа сайжирсан байна.	Бүс нутгийн бизнес эрхлэгчид, малчид, тариаланчдын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон нийтэд сурталчилан таниулах, түгээн дэлгэрүүлэх, бизнесийн түншлэлийг тогтоох, бүтээгдэхүүний чанар, стандарт, экспортын чадамж ба боломжийг дээшлүүлэх, бүс нутгийн хэмжээнд брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулах, хамтын ажиллагааг сайжруулах зорилготой “Зүүн бүсийн түншлэл-Хэнтий 2023” үзэсгэлэн худалдааг 2023 оны 11 дүгээр сарын 03-04-ны өдрүүдэд зохион байгуулж, Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгуудын баялаг бүтээгч 65 гаруй иргэн, аж ахуйн нэгж 180 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 33.0 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн.	100%
80	8.2. Аялал жуулчлал	8.2.1. Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, чанар, стандартыг сайжруулж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэн жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	-	жуулчдын тоо өссөн эсэх	дотоодын жуулчид 48,6 мянга	Аялал жуулчлалын бүтээгдэхүүн, үйлчилгээг нэмэгдүүлж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	Жил бүр 5-6 эвент арга хэмжээнүүд тогтмол зохион байгуулж гадаадын 161, дотоодын 10980 жуулчин, тур оператор 30 гаруй ХХК оролцож үзэж сонирхсон байна. 2022 онд дотоодын жуулчид 54.8 мянга гадаадын жуулчид 719, 2023 онд гадаадын 3668, дотоодын 91607 болж, дотоодын жуулчдын тоо 36.8 хувиар өссөн үзүүлэлттэй байна.	100%
81		8.2.2. “Мянганы суут хүн Чингис хаан цогцолбор”	УТХО-3500.0,	гүйцэтгэлийн хувиар	“Мянганы суут хүн Чингис хаан”	“Мянганы суут хүн Чингис хаан” цогцолборуудын	Батноров сумын “Тэнгэрийн андгай хөшөөт цогцолбор”, Биндэр сумын “Их Хуралдай” цогцолборын бүтээн	90%

		байгуулж, Монголын нууц товчооны дурсгалт газруудыг хамгаалах, олон улсад сурталчлан таниулах, дэд бүтцээр /автозам, эрчим хүч, инженерийн шугам сүлжээ/ холбох ажлуудыг үе шаттай зохион байгуулж, түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлнэ.	ОНТ-947.3		цогцолборуудын гүйцэтгэл 40%	ажлын үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж, гүйцэтгэлийг 90% хүргэнэ.	байгуулалтын ажил 100% бүрэн дууссан. Норовлин сумын "Шихихутаг-Их засаг" цогцолборын ажлуудын дундаж гүйцэтгэл 94%-тай, Дэлгэрхаан сумын "Монголын нууц товчоо" цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл 96%-тай үргэлжилж байна. Бэрх тосгон дахь Монголын далд уурхайн музей, сургалт мэдээллийн төвийн ажил 98%-тай байна. Нийт 6 цогцолборын гүйцэтгэлийн дундаж 94.6%-д хүрсэн байна.	
82		8.2.3. Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төслийг Хэнтий аймагт хэрэгжүүлж, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын орлогыг нэмэгдүүлнэ.	АХБ 50000,0	хэрэгжилтээр	төслийн төлөвлөлт хийгдэж байна.	төлөвлөгөөний дагуу төсөл хэрэгжиж хэрэгжсэн байна.	"Хэнтий аймгийн Дадал суманд байгуулж буй "Чингис хаан" аялал жуулчлалын цогцолборын "Мэдээллийн төв"-ийн ажлын зураг төсөл, ерөнхий төлөвлөгөө, орчны тохижилтын эх загвар зураг төсөл боловсруулах ажил 90%-тай хийгдэж байна. Чингис хаан аялал жуулчлалын цогцолборын "Мэдээллийн төв"-ийн суурийн ухалтын ажил 100% дууссан. Чингис хаан аялал жуулчлалын цогцолборын ерөнхий төлөвлөгөөний талбайд "Археологийн авран хамгаалах хайгуул судалгаа"-ны ажил хийгдсэн. Хатуу хог хаягдлын 2-р зэргийн ландфилл байгууламжийн ажил 100% дуусаж, шаардлагатай машин техник, тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаж ашиглалтад орсон."	70%
83		8.2.4. Орон нутгийн онцлогт тохируулан аялагч, амрагч, жуулчдыг татах төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг	-	шинээр бий болсон бүтээгдэхүүн, үйлчилгээний тоогоор	аялал жуулчлалын вэб сайт, виртуал музей-г ашиглалтад оруулсан.	1-ээс доошгүй төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгосон байна.	Түүх, соёлын өв, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газрууд, орон нутгийн онцлогт тохируулан аялагч, амрагч, жуулчдыг татах төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүнийг хөгжүүлэх зорилгоор 4 жуулчны баазыг түшиглэн 1-3 үйлчилгээг үзүүлж жилдээ 120 орчим	100%

		шинээр бий болгож, хөгжүүлнэ.					амрагч, жуулчдад үйлчилгээг хүргэж байна.	
84	8.3. Тогтвортой хөдөө аж ахуй	8.3.1. Гол нэрийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлээр хангана.	50.0 сая ОНТ	гүйцэтгэлээр	Мах 100%, төмс 100%, хүнсний ногоог 60%-г дотоодоос хангаж байна.	Мах 100%, төмс 100%, хүнсний ногооны дотоодоос хангах хэмжээг нэмэгдүүлнэ.	Хэрлэн, Норовлин, Баян-Адарга, Өмнөдэлгэр сумын 10 аж ахуйн нэгж үхрийн мах 450 тн, хонины мах 540 тн, ямааны мах 360 тн тус тус бэлтгэн нийт 1350тн мах нөөцлөөд байна. Малын мах 95.7, Гурил 255, Гурилан бүтээгдэхүүн 27.5, Төрөл бүрийн будаа 79.0, Хуурай сүү 28.9, Өндөг 7.5, Ургамлын тос 51.2, Төмс 420.5, Хүнсний ногоо 210.8, Элсэн чихэр 58.9, Давс 38.9, Савласан ус 70.5тн тус тус хүнсний нөөцтэй, чанарын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой, хүртээмжтэй хангасан.	100%
85		8.3.2. Аймгийн махны үйлдвэрүүдийн үйл ажиллагааг дэмжиж, махны экспортын хэмжээг нэмэгдүүлнэ.	-	гүйцэтгэлээр	"Мах Экспорт" ХХК нь ОХУ-руу 25тн адууны мах экспортлоод байна.	Махны экспортын хэмжээ нэмэгдсэн байна.	Аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хүрээнд 2022 оны хаврын улиралд 60 тн мах, 6 аж ахуйн нэгж 623 тн мах нөөцөлж бэлтгэл ажлыг хангаж ажилласан. "Хүнсний хангамж-Аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд үндсэн хөрөнгө бэлтгэх эх үүсвэрийн зээлэнд хамрагдах 5 аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлснээр 1.6 тэрбум төгрөгийн зээл авч Өмнөдэлгэр, Хэрлэн суманд мах боловсруулах анхан шатны 3 үйлдвэр шинээр бий болоод байна.	100%
86		8.3.3. Бэлчээрийг усжуулах, худагжуулах ажлыг үргэлжлүүлэн малын бэлчээрийн нөөцийг нэмэгдүүлж, тогтвортой байдлыг хангана.	-	тоогоор	28 гүн өрмийн худаг шинээр гаргасан.	28-аас багагүй худаг шинээр гаргана.	Улсын төсвийн 120.0 сая.төг, малын тоо толгойн албан татварын 489.6 сая.төг, малчдын санхүүжилт 100.0 сая.төг, нийт 709.6 сая төгрөгийн хөрөнгөөр 16 суманд 47 худаг шинээр гаргаж, 70.5 мянган га бэлчээрийг усжуулсан.	100%
87		8.3.4. Малын чанар, ашиг шим, үүлдэр	32,0	гүйцэтгэлээр	2500 галшарын ямаа, 3250	-	Хүнс, Хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн 2023.10.16-ны өдрийн	100%

		угсааг сайжруулж, малын тоог чанарт шилжүүлж, малын генийн санг хамгаалж, биотехнологийн ололтыг нэвтрүүлэх замаар эрчимжсэн мал аж ахуйн салбарыг идэвхжүүлнэ.			адуунд үзлэг ангилалт хийсэн. Мөн 155 үнээ, 219 хонь, нийт 374 толгой малд зохиомол хээлтүүлэг хийсэн.		хуралдаанаар Хэнтий аймгийн Дадал суманд үржүүлж буй Мах-сүүний хосолмол ашиг шимтэй дадлын ухаа үхрийг “Дадалын ухаа” үүлдрээр батлуулсан. ОНТөсвийн 12.8 сая төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үүлдэр омгийн 7.2 мян.тол малд үзлэг ангилалт хийж, 790 толгой малыг ээмэгжүүлж, бүртгэлжүүлсэн. Ангилалтад хамрагдсан нийт малын 33.0%-г цөм сүрэгт, 55.7%-г үржлийн сүрэгт, 11.3%-г хэрэгцээний сүрэгт тус тус бүртгэсэн. Улсын төсвийн 37.5 сая төгрөгийн хөрөнгөөр Батширээт, Дадал, Батноров, Норовлин сумдын 41 өрх, 2 аж ахуйн нэгжийн 267 үнээнд Герефорд, 180 үнээнд Ангус, 280 үнээнд Симменталь үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үрээр, нийт 727 үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн. Үхрийн зохиомол хээлтүүлгийн техникч бэлтгэх танхим, дадлага хосолсон 80 цагийн мэргэжлийн чадамж олгох сургалтад 8 иргэн хамрагдаж эрхийн гэрчилгээ авсан.	
88		8.3.5. Мал, амьтны эрүүл мэндийг хамгаалах, мал, амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангаж, малаас хүнд дамжих халдварт болон гоц халдварт өвчнөөс нийтийн эрүүл мэндийг хамгаална.	534,1	гүйцэтгэлээр	4 төрлийн халварт өвчнөөс урьдчилан сэргийлсэн.	Мал амьтны гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний ариун цэвэр эрүүл ахуйн шаардлага хангагдаж, алварт өвчний гаралт буурсан байна.	4 төрлийн халдварт өвчний өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 595.0 мянган мал хамруулахаас 559.8 мянган мал хамруулж гүйцэтгэл 94.1 хувьтай хийгдсэн. Малаас хүнд халдварладаг галзуу, боом болон бог малын мялзан, хонины цэцэг өвчний нийт 658.9 мян.м2 талбайд голомтыг халдваргүйтгэх ажлыг Мал эмнэлгийн тасаг, үйлчилгээний нэгжүүд хамтран гүйцэтгэсэн халдварт өвчний гаралт өмнөх оноос 40%-иар буурсан.	100%

89		8.3.6. Тариалангийн нийт эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, голлох нэр төрлийн таримлаар дотоодын хэрэгцээг хангаж, бусад ашигт таримлын үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	-	гүйцэтгэлээр	2022 онд атаршсан 5140 га талбайг шинээр эргэлтэд оруулсан. Хүнсний ногоо 271,5 га-д тариалалт хийж, 3317 тн ургац хураан авч өмнөх оны тариалалтаас 36.6 га-р нэмэгдүүлж хүн амын хэрэгцээний 44,5 хувийг хангаж ажилласан.	Тариалангийн талбайн эргэлтийг нэмэгдүүлж, голлох нэр төрлийн тарималаар дотоодын хэрэгцээг хангаж, ашигт тарималын үйлдвэрлэл нэмэгдсэн байна.	2023 онд Цэнхэрмандал, Жаргалтхаан, Хэрлэн сумдад үр тариа, төмс хүнсний ногоо, ногоон тэжээл тариалах иргэн ААНэгжид нийт 5700 га атаршсан тариалангийн талбайг эргэлтэд оруулсан. Хүнсний ногоо 295.2 га-д тариалалт хийж, 3447.8 тн ургац хураан авч хүн амын хэрэгцээний 34.6 хувийг хангаж ажилласан.	90%
90		8.3.7. Мал, малын гаралтай түүхий эдийг боловсруулах үйлдвэр байгуулж, ажлын байрыг нэмэгдүүлж, малчдын орлогыг өсгөж, хөдөө аж ахуйн гаралтай бараа, бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлнэ.	-	гүйцэтгэлээр	Хэрлэн суманд 1 ноос боловсруулах үйлдвэр үйл ажиллагаа явуулдаг.	малын гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэр байгуулна.	"Хүнсний хангамж-Аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд үндсэн хөрөнгө бэлтгэх эх үүсвэрийн зээлэнд хамрагдах 5 аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлснээр 1.6 тэрбум төгрөгийн зээл авч Өмнөдэлгэр, Хэрлэн суманд мах боловсруулах анхан шатны 3 үйлдвэр, Биндэр, Дадал суманд сүү боловсруулах үйлдвэр тус тус баригдан, тоног төхөөрөмжөө шинэчлэн үйл ажиллагаагаа эхлүүлж 15-н ажлын байр шинээр бий болоод байна.	100%
91		8.3.8. Жижиг, дунд үйлдвэр, бизнес эрхлэгчдэд зориулан санхүүжилтийн шинэ боломжийг нэвтрүүлж, оновчтой хуваарилж, бизнес инкубатор төвөөр бойжуулж, жижиг, дунд үйлдвэр эрхлэгчдийн ур чадварыг хөгжүүлэн,	-	гүйцэтгэлээр	ЖДҮДДСангийн хөнгөлөлттэй зээлд 5 аж ахуйн нэгж, 8 иргэн хамрагдаж 730 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авсан. сумдын сум хөгжүүлэх санд 78 иргэнд 627.3 сая төгрөгийн	ЖДҮ, бизэес эрхлэгчдэд санхүүжилтийн боломж нээгдэж, бизнес инкубаторын үйл ажиллагаа сайжирсан байна.	2023 онд Хүнс, хөдөө аж ахуйн газар шинэ байртай болсноор хуучин хүнс, хөдөө аж ахуйн байранд Бизнес Инкубатор төв шинээр бий болж, тус төвүүдэд 2 аж ахуйн нэгж, 7 иргэн бойжиж байна. БИТ-н 3 бойжигчийг Хоршоо хөгжүүлэх сангаас 75.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан. Best хөтөлбөрийн тэтгэлэгт сонгон шалгаруулалтаас 1 аж ахуйн нэгж 10 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэгт шалгарч үйл ажиллагаагаа	100%

		өрсөлдөх чадварыг дээшлүүлж, орлогыг нэмэгдүүлнэ.			хөнгөлөлттэй зээл олгосон. Бизнес инкубатор төвд 6 ААН үйл ажиллагаа явуулж байна.		явуулж байна. Гарааны бизнес эрхлэгчдийг Best хөтөлбөрийн үе шаттай сургалтад хамруулахаас гадна ЖДҮГазар, Монгол банкны хамтарсан "Санхүүгийн анхан шатны" боловсрол олгох 2 удаагийн сургалтад хамруулан чадавхжууллаа.	
92	8.3. Тогтвортой хөдөө аж ахуй	8.3.9. Усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх замаар тэжээл, төмс, хүнсний ногооны тариалангийн үйлдвэрлэлийг өсгөнө.	-	гүйцэтгэлээр	Хэрлэн суманд дамарт бороожуулагч авсан.	Услалтын системийн ажил 10 хувиар нэмэгдсэн байна.	"Хүнсний ногооны үйлдвэрлэл ба усалгаатай хөдөө аж ахуй" төслийн хүрээнд Азийн хөгжлийн банкны 100 хувийн санхүүжилтээр Хэрлэн суманд 700 га-д услалтын систем шинээр байгуулах зураг төслийн ажил хийгдэж хашаажуулалт болон толгойн барилгын ажил эхлээд 30 гаруй хувийн хэрэгжилттэй байна. Барилга угсралтын ажил 70 хувьтай явагдаж байна.	70%
<b>Үнэлгээний дундаж</b>								<b>94.13</b>

**Үнэлгээтэй танилцсан:**  
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

/Ж.ГАНТУЛГА/

**Үнэлгээг хянасан:**  
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
 ХЭЛТСИЙН ДАРГА

/Ц.ГАНЧИМЭГ/

**Хэрэгжилтийг үнэлсэн:**  
 ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ  
 ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

/Б.УНДРАХЖАРГАЛ/